



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/54/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833 Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Г.Ганчимэг Утас: 88268424 Цахим хаяг: <a href="mailto:ganaa_7133@yahoo.com">ganaa_7133@yahoo.com</a> Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	15
Залруулсан алдаа Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдааны залруулга хийгдээгүй .....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР СУМЫН БАЯН-ОЙТ  
ЦОГЦОЛБОРЫН ЗАХИРАЛ  
Л. АЮУРЗАНА ТАНАА

2021.02.25 № 2/65

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93,9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2021 А4 ТООТ

• 005021026

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>91,323,981.95</b>	<b>88,540,354.05</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,302,872.00</b>	<b>66,125.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	66,125.00	66,125.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,236,747.00</b>	<b>00.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	2,236,747.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>89,021,109.95</b>	<b>88,474,229.05</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>431,539.12</b>	<b>143,818.22</b>
35130	Эм боох материал	431,539.12	143,818.22
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>88,589,570.83</b>	<b>88,330,410.83</b>
35410	Бичиг хэргийн материал	1,877,490.00	3,144,500.00
35420	Аж ахуйн материал	21,674,782.80	27,670,832.80
35440	Түлш, шатах тослох материал	240.56	515,240.56
35450	Барилгын засварын материал	1,412,000.00	13,675,500.00
35460	Хүнсний материал	2,851,640.07	624,472.07
35470	Бусад хангамжийн материал	60,773,417.40	42,699,865.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,312,198,447.63</b>	<b>1,297,662,730.51</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,312,198,447.63</b>	<b>1,297,662,730.51</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,170,723,447.63</b>	<b>1,156,187,730.51</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,158,242,125.71	1,158,242,125.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-44,879,160.20	-64,641,874.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,942,178.00	63,579,058.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,034,689.46	-38,822,685.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,560,227.86	53,178,127.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,131,201.15	-17,586,415.52
39209	Зам, гүүрийн байгууламж	57,500.00	57,500.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-57,500.00	-57,500.00
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,052,720.00	1,052,720.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-156,816.63	-168,850.95
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,681,863.50	746,509.50
39217	Ном	3,446,200.00	609,016.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>141,475,000.00</b>	<b>141,475,000.00</b>
39301	Программ хангамж	1,312,000.00	682,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,312,000.00	-682,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	141,475,000.00	141,475,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,403,522,429.58</b>	<b>1,386,203,084.56</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>22,499.92</b>	<b>22,499.92</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>22,499.92</b>	<b>22,499.92</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>22,499.92</b>	<b>22,499.92</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>22,499.92</b>	<b>22,499.92</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	22,499.92	22,499.92
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,403,499,929.66</b>	<b>1,386,180,584.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,403,499,929.66</b>	<b>1,386,180,584.64</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	248,814,143.50	248,814,143.50
51101	Өмч: - төрийн	248,814,143.50	248,814,143.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>988,539,672.73</b>	<b>971,220,327.71</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	988,539,672.73	988,539,672.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-17,319,345.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,146,113.43	166,146,113.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,403,522,429.58</b>	<b>1,386,203,084.56</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>617,586,515.52</b>	<b>659,797,800.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,842,315.52</b>	<b>00.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>7,842,315.52</b>	<b>00.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,842,315.52	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,842,315.52	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>609,744,200.00</b>	<b>659,797,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>488,337,600.00</b>	<b>541,581,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	488,337,600.00	541,581,600.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>121,406,600.00</b>	<b>118,216,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,406,600.00	118,216,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>632,415,507.41</b>	<b>672,134,033.13</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>632,415,507.41</b>	<b>672,134,033.13</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>629,786,040.91</b>	<b>665,831,650.15</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>335,362,890.00</b>	<b>398,274,446.72</b>
210101	Үндсэн цалин	335,362,890.00	294,770,364.13
210102	Нэмэгдэл	00.00	78,891,100.00
210104	Урамшуулал	00.00	24,612,982.59
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,604,952.35</b>	<b>49,865,635.87</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,604,952.35	33,817,035.87
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	4,012,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	3,209,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	802,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	8,024,300.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>116,906,600.00</b>	<b>104,978,060.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,181,864.00	962,900.00
210302	Түлш, халаалт	37,672,144.00	35,512,728.00
210303	Цэвэр, бохир ус	20,052,592.00	14,502,432.00
210304	Байрны түрээс	45,000,000.00	54,000,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,923,429.34</b>	<b>24,370,277.43</b>
210401	Бичиг хэрэг	1,545,200.00	1,351,490.00
210402	Тээвэр, шатахуун	2,651,092.84	1,385,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	928,861.50	1,201,585.43
210404	Ном, хэвлэл	90,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,000.00	903,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,428,275.00	2,962,850.00
210408	Бараа материал актлсны зардал	00.00	16,565,952.00
2105	<b>Норматив зардал</b>	<b>90,787,565.00</b>	<b>50,843,808.90</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	679,720.90
210502	Хоол, хүнс	90,787,565.00	50,099,288.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	64,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,672,220.00</b>	<b>2,701,900.00</b>
210604	Урсгал засвар	3,672,220.00	2,701,900.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,060,500.00</b>	<b>370,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	810,500.00	120,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,467,884.22</b>	<b>34,427,521.23</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,599,900.00	805,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,867,984.22	33,622,521.23

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,629,466.50	6,302,382.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	900,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	482,250.00	1,938,140.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	482,250.00	1,938,140.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,247,216.50	3,664,242.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,247,216.50	3,664,242.98
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-14,828,991.89</b>	<b>-12,336,233.13</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	4,983,111.89
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	4,983,111.89
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-4,983,111.89
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-14,828,991.89</b>	<b>-17,319,345.02</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>619,287,600.00</b>	<b>659,797,800.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,543,400.00</b>	<b>00.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	9,543,400.00	00.00
120009	Бусад орлого	9,543,400.00	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>609,744,200.00</b>	<b>659,797,800.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	488,337,600.00	541,581,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	488,337,600.00	541,581,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	121,406,600.00	118,216,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	121,406,600.00	118,216,200.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>619,287,600.00</b>	<b>641,681,384.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>619,287,600.00</b>	<b>641,681,384.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>616,656,133.50</b>	<b>635,379,001.02</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,928,247.00	395,751,635.59
210101	Үндсэн цалин	283,586,238.00	292,247,553.00
210102	Нэмэгдэл	30,056,553.00	78,891,100.00
210104	Урамшуулал	26,285,456.00	24,612,982.59
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,183,300.00</b>	<b>50,151,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,061,800.00	34,103,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,280,300.00	4,012,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,624,400.00	3,209,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	656,100.00	802,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,560,700.00	8,024,300.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>114,106,600.00</b>	<b>104,978,060.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,181,864.00	962,900.00
210302	Түлш, халаалт	34,872,144.00	35,512,728.00
210303	Цэвэр, бохир ус	20,052,592.00	14,502,432.00
210304	Байрны түрээс	45,000,000.00	54,000,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,042,461.50</b>	<b>7,805,285.43</b>
210401	Бичиг хэрэг	762,600.00	1,002,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,425,000.00	1,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	928,861.50	1,261,585.43
210404	Ном, хэвлэл	166,200.00	585,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	903,400.00

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,579,800.00	2,153,300.00
2105	Норматив зардал	91,906,475.00	57,248,920.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,700.00	2,630,000.00
210502	Хоол, хүнс	90,804,375.00	47,872,120.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,050,400.00	6,746,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,171,150.00	16,486,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,521,000.00
210604	Урсгал засвар	7,171,150.00	14,965,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,918,000.00	887,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,718,000.00	637,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,399,900.00	2,070,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,399,900.00	2,070,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,631,466.50	6,302,382.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	902,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	902,000.00	700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	482,250.00	1,938,140.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	482,250.00	1,938,140.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,247,216.50	3,664,242.98
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,247,216.50	3,664,242.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	18,116,416.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	18,116,416.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	18,116,416.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	18,116,416.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	18,116,416.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=- (4)-(5)	00.00	-18,116,416.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	107,339,143.50	165,234,686.00	-53,523,126.95	00.00	219,050,702.55
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,030,525.83	00.00	-25,030,525.83
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	988,539,672.73	00.00	1,403,499,929.66
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	988,539,672.73	00.00	1,403,499,929.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	988,539,672.73	00.00	1,403,499,929.66
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,319,345.02	00.00	-17,319,345.02
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,814,143.50	166,146,113.43	971,220,327.71	00.00	1,386,180,584.64

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	659,797,800.00	654,195,417.02	5,602,382.98	99.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	659,797,800.00	654,195,417.02	5,602,382.98	99.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	659,015,400.00	653,495,417.02	5,519,983.0	99.2
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	398,977,100.00	395,751,635.59	3,225,464.4	99.2
210101	Үндсэн цалин	292,248,000.00	292,247,553.00	447.0	100.0
210102	Нэмэгдэл	78,891,100.00	78,891,100.00	0.0	100.0
210104	Урамшуулал	27,838,000.00	24,612,982.59	3,225,017.4	88.4
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,151,700.00	50,151,700.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	34,103,100.00	34,103,100.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,012,100.00	4,012,100.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,700.00	3,209,700.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	802,500.00	802,500.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,024,300.00	8,024,300.00	0.0	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	106,916,200.00	104,978,060.00	1,938,140.0	98.2
210301	Гэрэл, цахилгаан	2,217,600.00	962,900.00	1,254,700.0	43.4
210302	Түлш, халаалт	35,236,600.00	35,512,728.00	-276,128.0	100.8
210303	Цэвэр, бохир ус	15,462,000.00	14,502,432.00	959,568.0	93.8
210304	Байрны түрээс	54,000,000.00	54,000,000.00	0.0	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,436,300.00	9,260,285.43	176,014.6	98.1
210401	Бичиг хэрэг	1,004,100.00	1,002,000.00	2,100.0	99.8
210402	Тээвэр, шатахуун	1,900,000.00	1,900,000.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,513,900.00	1,501,585.43	12,314.6	99.2
210404	Ном, хэвлэл	691,200.00	690,000.00	1,200.0	99.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,144,600.00	2,013,400.00	131,200.0	93.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,182,500.00	2,153,300.00	29,200.0	98.7
2105	<b>Норматив зардал</b>	63,743,200.00	63,648,920.00	94,280.0	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,131,800.00	4,130,000.00	1,800.0	100.0
210502	Хоол, хүнс	47,945,400.00	47,872,120.00	73,280.0	99.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,666,000.00	11,646,800.00	19,200.0	99.8
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,490,000.00	17,486,400.00	3,600.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,521,000.00	2,521,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	14,969,000.00	14,965,400.00	3,600.0	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	920,100.00	887,000.00	33,100.0	96.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	670,100.00	637,000.00	33,100.0	95.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.0	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11380800.00	11331416.00	49,384.0	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,481,600.00	18,400.0	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,880,800.00	6,849,816.00	30,984.0	99.5

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	782400.00	700000.00	82,400.0	89.5
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	782,400.00	700,000.00	82,400.0	89.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	782,400.00	700,000.00	82,400.0	89.5
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	659,797,800.00	654,195,417.02	5,602,383.0	99.2
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	541,581,600.00	537,917,357.02	3,664,243.0	99.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	541,581,600.00	537,917,357.02	3,664,243.0	99.3
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	118,216,200.00	116,278,060.00	1,938,140.0	98.4
132001	Орон нутгийн төсвөөс	118,216,200.00	116,278,060.00	1,938,140.0	98.4
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.0	100.0
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	38.00	38.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	0.0	100.0
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	375	325	50	86.7
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	375	325	50	86.7
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	375	325	50	86.7
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	37	37	0.0	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	21	21	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16	0.0	100.0

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Л.Аюурзана танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-ээс 2021 оны 02 дугаар сарын 25-ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн 10 дугаар цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 64 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх ажлыг хэвшүүлж багшийн хөгжлийн төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах.
- “Сайн багш” хөтөлбөрийг хэрэгжилтийг ханган ажиллаж ээлжит хичээлийн бэлтгэлийг чанаржуулж, ЗАН, секц, багаараа хамтран нээлттэй, судалгаат, хамтын, зочинтой хичээлүүдийг явуулдаг менежментийг сургууль, цэцэрлэгтээ хэрэгжүүлэх.
- Хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан, олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийн туршлагаас суралцах
- Хүүхдэд тавих хараа хяналт, аюулгүй байдал, эрх хамгааллын талаар багш, эцэг эхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 677117,1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13542,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1386203,1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 17319,3 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
<b>Б</b>			
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>91,324.0</b>	<b>88,540.4</b>	<b>(2,783.6)</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,302.9	66.1	(2,236.7)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	89,021.1	88,474.2	(546.9)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,312,198.4</b>	<b>1,297,662.7</b>	<b>(14,535.7)</b>
Үндсэн хөрөнгө	1,409,769.8	1,419,622.1	9,852.2
Хуримтлагдсан элэгдэл	(97,571.4)	(121,959.3)	(24,388.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,403,522.4</b>	<b>1,386,203.1</b>	<b>(17,319.3)</b>
Өр төлбөр	22.5	22.5	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,403,499.9	1,386,180.6	(17,319.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,403,522.4</b>	<b>1,386,203.1</b>	<b>(17,319.3)</b>

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 66,1 мянган төгрөг болж 2236,7 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд үүссэн цалин хөлсний тооцоотой холбоо авлагыг барагдуулсан одоо 66,1 мянган төгрөгийн Мобиком ХХК-аас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88474,2 мянган төгрөг болж 546,8 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын даргын 2020.12.12 ний өдрийн Б/28 тоот тушаалаар 16565,9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1419622,0 мянган төгрөг болж 9852,2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 18116,4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, бараа материалын данснаас 5953,5 мянган төгрөгийн хөрөнгийн шилжүүлэн бүртгэсэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 49 дүгээр тогтоолоор 14217,6 мянган төгрөгийн хөрөнгө актталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 11900,6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6010,0 мянган төгрөгийн тавилга эд хөрөнгө нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 142157,0 мянган төгрөг болж 630,0 мянган төгрөгөөр буурсан нь программ хангамжийн дансанд бүртгэлтэй ашиглалтгүй байгаа программ хангамжийг данснаас хассанаас шалтгаалжээ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1386180,5 мянган төгрөг болж 17319,3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 17319,3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 659797,8 мянган төгрөг болж, өмнөх оноос 42211,2 мянган төгрөгөөр буюу 6,8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 7842,3 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос буурсантай, тусламж санхүүжилтийн орлого 50053,6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 53244,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 3190,4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал 672134,0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 39718,5 мянган төгрөгөөр буюу 6,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байрны түрээсийн зардал, норматив зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал нэмэгдсэнтэй холбоотой байна

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 863479,7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 863479,7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, ажиллагсдын тоог 38 орон тоогоор дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 108115,0 мянган төгрөгөөр бууруулан 755364,7 мянган төгрөгөөр баталж 2 удаагийн зохицуулалт хийж 659797,8 мянган төгрөгөөр ажиллагсдын тоог 37 орон тоогоор баталж цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, тээвэр шатахуун, тавилга эд хогшлын, томилолтын зардлыг буруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлж баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 659797,8 мянган төгрөгийн төсөв баталснаас 654195,4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 541581,6 мянга, орон нутгийн төсвөөс 118216,2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 541581,6 мянга, орон нутгийн төсвөөс 118216,2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 659797,8 мянган

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 654195,4 мянган төгрөгийг зарцуулж 5602,3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 654195,4 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 3225,4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1938,1 мянга, хангамж бараа материалын зардлыг 176,0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 5602,3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний зардлыг 5602,3 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

<i>Хүснэгт-2 Төсвийн бүлэгтэй тайлан хөтөлбөр арга хэмжээгээр</i>				<i>төгрөгөөр</i>	
Код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
100	ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	659,797,800.00	654,195,417.02	5,602,382.98	99.2
101	АРГА ХЭМЖЭЭ 80109	118,216,200.00	116,278,060.00	1,938,140.00	98.4
102	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,216,200.00	116,278,060.00	1,938,140.00	98.4
103	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	118,216,200.00	116,278,060.00	1,938,140.00	98.4
104	Бараа, үйлчилгээний зардал	118,216,200.00	116,278,060.00	1,938,140.00	98.4
117	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,916,200.00	104,978,060.00	1,938,140.00	98.2
198	ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	782,400.00	700,000.00	82,400.00	89.5
199	АРГА ХЭМЖЭЭ 80802	782,400.00	700,000.00	82,400.00	89.5
200	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	782,400.00	700,000.00	82,400.00	89.5
201	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	782,400.00	700,000.00	82,400.00	89.5
264	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	782,400.00	700,000.00	82,400.00	89.5
268	Бусад урсгал шилжүүлэг	782,400.00	700,000.00	82,400.00	89.5
296	ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	47,945,400.00	47,872,120.00	73,280.00	99.8
297	АРГА ХЭМЖЭЭ 81807	47,945,400.00	47,872,120.00	73,280.00	99.8
298	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,945,400.00	47,872,120.00	73,280.00	99.8
299	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	47,945,400.00	47,872,120.00	73,280.00	99.8
300	Бараа, үйлчилгээний зардал	47,945,400.00	47,872,120.00	73,280.00	99.8
328	Хоол, хүнс	47,945,400.00	47,872,120.00	73,280.00	99.8
394	ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	455,670,400.00	455,518,054.43	152,345.57	100.0
395	АРГА ХЭМЖЭЭ 81834	455,670,400.00	455,518,054.43	152,345.57	100.0
396	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	455,670,400.00	455,518,054.43	152,345.57	100.0
397	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	455,670,400.00	455,518,054.43	152,345.57	100.0
398	Бараа, үйлчилгээний зардал	455,670,400.00	455,518,054.43	152,345.57	100.0
399	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	371,139,100.00	371,138,653.00	447.00	100.0
405	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,671,900.00	46,671,900.00	-	100.0
416	Хангамж, бараа материалын зардал	5,091,700.00	5,046,885.43	44,814.57	99.1
424	Нормативт зардал	15,797,800.00	15,776,800.00	21,000.00	99.9
428	Эд хогшил худалдан авах	4,669,000.00	4,665,400.00	3,600.00	99.9
437	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	920,100.00	887,000.00	33,100.00	96.4
447	Бараа үйлчилгээний бусад зардал	11,380,800.00	11,331,416.00	49,384.00	99.6
492	ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол	37,183,400.00	33,827,182.59	3,356,217.41	91.0
493	АРГА ХЭМЖЭЭ 81835	37,183,400.00	33,827,182.59	3,356,217.41	91.0
494	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,183,400.00	33,827,182.59	3,356,217.41	91.0
495	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	37,183,400.00	33,827,182.59	3,356,217.41	91.0
496	Бараа, үйлчилгээний зардал	37,183,400.00	33,827,182.59	3,356,217.41	91.0
503	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,479,800.00	3,479,800.00	-	100.0
514	Хангамж, бараа материалын зардал	4,344,600.00	4,213,400.00	131,200.00	97.0
526	Эд хогшил худалдан авах	1,521,000.00	1,521,000.00	-	100.0

*Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байршуулбал зохих 151 мэдээллээс 136 мэдээллийг бүрэн байршуулсан, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцорсон 13 мэдээлэл, байна. Үүнээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16441.6 мянга, зарлагын 10230.0 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 64938.0 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт-3

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа болоогүй	Хугацаа хоцроож байршуулсан	Мэдээллийг хугацаандаа байршуулаагүй	Үүнээс Хугацаа хоцроож байршуулсан												
								Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн	Тухайн жилийн төсөвт өрсөн нэмэлт, өөрчлөлт	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний төсвийн	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /мян.төг/			Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хөлг					
								Тоо	Тоо	Тоо	Тоо	Тоо	Орлого	Зарлага	Тоо	Дүн				
1	Бүтэн жил	11	11	9	2															
2	Хагас жил	4	4	4		0														
3	Улсрал бүр	1	4	3		1														
4	Сар бүр	3	36	32		4														
5	Тухай бүр	8	96	88		8														
	Нийт	27	151	134	2	13	0	3	2	2	1	1	16,442	10,230	4	64,938.0				

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1851,6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг төлж, зөвлөмжийн биелэлтийг 2020.06.28 ний өдөр ирүүлж хэрэгжилт 100 хувьтай байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 60112,4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 652,4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 59460,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа** Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдааны залруулга хийгдээгүй

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 652,4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

Хүүхдийн хоолны зардлыг хүүхдийн тоо, меню, нярвын тайланг тулгаж шалгахад нийт 14892 хүүхэд өдөрт 37619.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Засгийн газрын 2019.12.18 ний "хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тушаалаар нэг өдрийн хүүхдийн хоолны зардлыг 2475 төгрөгөөр тогтоосон байхад 2526 төгрөгөөр олгож төсвийг 652.4 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2019.12.18 ний "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоолын 1. Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тус тус тогтоосугай". гэсэн заалтыг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Тогтоосон нормативаас хэтрүүлэн зарцуулсан 652,4 мянган төгрөгийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 59460,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Хуучин өргөтгөлийн гадна пасад хийхээр тайлант онд барилгын засварын материалын данс 13675,5 мянган төгрөгийг үлдэлдэлтэй байна. Төсөвт зохицуулалт хийлгэн их хэмжээний нөөц бүрдүүлдэг явдлыг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргаж байгаа талаар дараагийн аудитаар анхаарч үзэх.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1.Зардлын данстай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:** Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 4900,0 мянган төгрөгөөр дрож, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал хийх зардлаас 560,0 мянган төгрөгөөр 2 ш сандал гадна талбайн сандал худалдан авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-тай нийцэхгүй байна.

**1.2. Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг зөвшөөрөлгүй зориулалт бусаар зарцуулсан байх.

**1.3. Өгсөн зөвлөмж:** Нормын хувцас зөөлөн эдлэлийн, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

##### **2. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16442,0 мянган, зарлагын 10230,0 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 64938,0 мянган төгрөгийн 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

**2.2 Эрсдэл:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

**2.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллүүдээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, өөрчлөлт, хөрөнгийн зардал, төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, орон тоонд орсон өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилган, цаашид хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### **3. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

**3.1 Илрүүлэлт:** Тус байгууллага 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга 2017 онд, сургууль цэцэрлэгийн цогцолбор барилга ашиглалтад орсон байхад, өмнө нь хийж байсан цэцэрлэгийн байр түрээслэх 45,0 сая төгрөгийн гэрээг цуцлаагүй өмнөх оны гүйцэтгэлээс 9000,0 төгрөгөөр нэмэгдүүлж, “Урт Наст Эх” ХХК-тай 54,0 сая төгрөгөөр байгуулж төсвийн үргүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах заалт зөрчсөн байна.

**3.2 Эрсдэл:** Төсвийг үр ашиггүй зарцуулах, өглөг авлага үүсэх эрсдэлтэй.

**3.3 Өгсөн зөвлөмж:** 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилүүдийн эхнээс элсэлтийн хэмжээг өөрийн байрны хүчин чадалд тохируулах байдлаар шат дараатай арга хэмжээ авч жил бүрийн төсвийн төслийн төсөл тусган хэрэгжүүлэх замаар стандартын шаардлагад нийцсэн байр танхимдаа багтаан үйл ажиллагаагаа явуулах. Үүнээс гарсан төсвийн хэмнэлтийг сургалтыг сайжруулах, боловсон хүчнээ чадваржуулах зэрэг үр ашигтай зүйл зарцуулах.

**3.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГАНЧИМЭГ  
ОГНОО: 2021.02.25

А.ЦЭЭНЯМ  
ОГНОО: 2021.02.25

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.02.25

**Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**5. Хавсралт 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо 2020	Аудитын нэр:	Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			Аудитын код: БНА-2021/54/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэг			Мянган төгрөг
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Хүүхдийн хоолны зардлыг хүүхдийн тоо, меню, нярвын тайланг тулгаж шалгахад нийт 14892 хүүхэд өдөрт 37619.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Засгийн газрын 2019.12.18 ний "хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тушаалаар нэг өдрийн хүүхдийн хоолны зардлыг 2475 төгрөгөөр тогтоосон байхад 2526 төгрөгөөр олгож төсвийг 652.4 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.	652.4	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
2	Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 4900.0 мянгант төгрөгөөр дрож, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал хийх зардлаас 280.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ш түшлэгтэй сандал 560.0 мянган төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан	5,460.0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
3	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээллээс 13 мэдээллийг хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
4	Тайлант онд байр түрээслэх гэрээг 2020.01.02 ний өдөр "Урт Наст Эх" ХХК-тай 54000,0 мянган төгрөгөөр байгуулж өмнөх оны гүйцэтгэлээс 9000,0 төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн үргүй зардал гаргасан байна.	54000,0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
ДҮН		60112,4			

oOo